



**МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ**

2019 оны 05 сарын 21 өдөр

Дугаар

A/178

Улаанбаатар хот

**Хэвлэл, мэдээллийн удирдах зөвлөл
байгуулах тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Монгол Улсын Засгийн газар, Азийн Хөгжлийн банкны хооронд байгуулсан 2018 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн санхүүжилтийн хэлэлцээрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж байгаа "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл"-ийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх олон нийтийн ойлголт, хандлагыг өөрчлөх мэдээллийн стратегийг боловсруулан хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулж, хяналт тавих чиг үүрэг бүхий Хэвлэл мэдээллийн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Дарга:

Г.Өнөрбаяр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга

Гишүүд:

С.Рэгзэн Хүн амын хөгжлийн газрын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн хэлтсийн дарга

Н.Сарангэрэл Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хэвлэлийн төлөөлөгч

Д.Энхтүвшин Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын Хэвлэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн

О.Намчин Монголын үндэсний радио телевизийн ММ

агентлагийн редактор

Б.Оргодол Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн "Тулга-5" студийн захирал

М.Баясгалан Сайдын зөвлөх, Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөө зөвлөлийн үндэсний зөвлөлийн тэргүүн

Б.Мөнхтуяа "Үндэсний хөгжлийг дэмжих сэтгүүлчдийн эвлэл" төрийн бус байгууллагын гишүүн

Нарийн бичгийн дарга: Хүн амын хөгжлийн газрын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн

Т.Мөнгөнцэцэг

2. Хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг ойлголт, хандлагыг өөрчлөх мэдээллийн стратегийг боловсруулан хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2019 оны 05 дугаар сард багтаан танилцуулахыг Удирдах зөвлөл (Г.Өнөрбаяр)-д даалгасугай.

3. Удирдах зөвлөлийн үйл ажиллагааг "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл"-ийн төлөвлөгөөнд тусгаж, дэмжлэг үзүүлж ажиллахыг Төслийн удирдах хороо (С.Мөнгөнчимэг)-нд үүрэг болгосугай.

